



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/116

Ховд

Хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэхь заалт, Улсын Онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 06 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Covid-19" халдварт өвчний дэгдэлт нэмэгдэж байгаатай холбогдуулан "Хязгаарлалт тогтоох тухай" аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/105 дугаар захирамжаар 2020 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 08.00 цагаас 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 08.00 цаг хүртэлх хугацааг 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 08.00 цаг хүртэл сунгасугай.

2. Хязгаарлалтын хугацаа сунгагдсантай холбогдуулан хяналтын постын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар /дэд хурандаа Б.Алтанбадралт/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Авто тээврийн төв /Н.Ирэхзаяа/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



02_00523

D/Zax-A/116-Da